



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 11 сарын 17 өдөр

Дугаар А/584

Хэрлэн сум

Сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдварын урьдчилан сэргийлэх
үзлэг зохион байгуулахад хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 10 тоот тогтоолын 6 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.4-д сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдварын эрт илрүүлэлтийг эрчимжүүлэн, эмчилгээний үр дүнг 90-с доошгүй хувьд хүргэнэ гэсэн зорилтын хүрээнд Баян-Овоо сум, Гурванбаян тосгонд сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдварын урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулахад 8,625,720 (найман сая зургаан зуун хорин таван мянга долоон зуун хорь) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Арга хэмжээг өндөр түвшинд зохион байгуулж, удирдлага, арга зүйгээр хангаж ажиллахыг Эрүүл мэндийн газрын дарга (Л.Мэндбаяр)-д, эрсдэлт бүлгийн хүн амыг бүрэн хамруулж ажиллахыг сумын Засаг дарга, тосгоны захирагч нарт тус тус үүрэг болгосугай.

3. Сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдварын урьдчилан сэргийлэх үзлэгт зарцуулагдах зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

4. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн зардлаас олгохыг Санхүү төрийн сангийн хэлтэс (С.Нямдаваа)-т, арга хэмжээнд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Д.Өнөрцэцэг)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

231011459

Аймгийн Засаг даргын 2022 оны
11 дугаар сарын 17-ны
дугаар захирамжийн хавсралт

Сүрьеэ, бэлгийн замаар дамжих
халдварын урьдчилан сэргийлэх үзлэгийн
зардлын тооцоо

Д/д	Зардлын нэр	Нэг бүрийн үнэ	Тоо ширхэг	Бүгд үнэ
1	Томилолт	49,030	10 хоног, 5 хүн	2,451,500
2	Шатахууны зардал	Дизель 3,760, 100 км-т 20 л	260 км	195,520
3	Бээлий	980	725 хос	710,500
4	Тэмбүүгийн тест	2,400	810	1,944,000
5	ДОХ-ын оношлуур	2,400	910	2,154,000
6	Тэмбүүгийн оношлуур (ТРНА)	8 хүн тун	150,000	1,170,200
7	Нийт дүн			8,625,720